



БУЛГАН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# БУЛГАН АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН байдал

Monthly bulletin of **STATISTICS**

2019/2  
[www.bulgan.nso.mn](http://www.bulgan.nso.mn)



# СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?

**www.1212.mn**

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН  
НЭГДСЭН САН

www.nso.mn сайтын  
Хэрэглэгчийн бүртгэлд  
бүртгүүлснээр цахим  
хаягаар тогтмол  
авч болно.

Monstat ezStat  
аппликейшн

1900-1212  
Лавлах утас

@statistic\_mn

Статистик  
мэдээлэл

Вндэсний Статистикийн  
Хорооны  
НОМЫН САН

Онлайн лавлах  
мессенжер  
8:30-17:30

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ

ХҮНД СУРТАЛ  
АВИЛГА

ҮГҮЙ НЭЭЛТТЭЙ  
ХҮРГЭНЭ

## ГАРЧИГ

Аргачлалын тайлбар.....	2
Товч танилцуулга.....	6
I. 1 Хүн ам.....	10
I. 4 Эрүүл мэнд .....	11
I. 6 Гэмт хэрэг .....	11
II.3 Үнэ.....	13
II.7 Аж үйлдвэр.....	18
II.14 Мал аж ахуй.....	19

## Аргачлалын тайлбар

### Хөдөлмөр

Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхлэгдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхитэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн төв бирж, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.

### Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулах, өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм эдийн засгийн арга хэмжээ юм. Тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалан өвчний, ажилгүйдлийн даатгал гэсэн төрлөөс нийгмийн даатгал бүрдэнэ.

Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.

Тэтгэвэр нь даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд (хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл)-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгө байна.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

### Эрүүл мэнд

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөд тооцно.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг тодорхойлохдоо тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулна.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох хүүхдийн эндэгдлийг тооцохдоо тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд хуваана.

Эндсэн эхийн тоонд жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэн эхийг хамааруулна.

Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшинг тооцохдоо тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиодлын тоог тухайн хугацааны хүн амын тоонд харьцуулна.

### Аюулт үзэгдэл, осол

Гамшиг гэж аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ.

Аюулт үзэгдэл гэж хүчтэй цасан болон шроон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг хамруулан ойлгоно. Техникийн холбогдолтой осол гэж үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга, байгууламж, шугам, сүлжээ эвдрэх, тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэргийг хамруулан ойлгоно.

### Гэмт хэрэг

Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ.

Гэмт хэргийн нийгмийн шинж чанар, аюулын хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Гэмт хэргийн тоог Монгол Улсын Эрүүгийн хуульд заасны дагуу гэмт хэргийн төрлөөр нэгтгэн гаргаж байна.

Тухайлбал:

- Хүний ам бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг
- Хүүхэд гэр бүл, нийгмийн эсрэг гэмт хэрэг
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг
- Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг
- Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг
- Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг
- Бусад гэмт хэрэг

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог тодорхойлохдоо нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог 18 ба түүнээс дээш насны хүн амын дундаж тоонд харьцуулна.

Дор дурьдсан этгээдэд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрүүгийн хэрэг үүсгэж, үндэслэл бүхий тогтоол гаргасан бол сэжигтнээр тооцно. Үүнд:

-Уг этгээдийг гэмт хэрэг үйлдэж байх үед буюу үйлдэл дор нь барьсан

-Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хохирогч буюу харсан хүн шууд заасан

-Уг этгээдийн бие, хувцас, эд зүйл, орон байранд гэмт хэргийн ул мөр тодорхой илэрч олдсон

-Уг этгээд хэргээ илчлэн ирсэн

-Гэмт хэрэгт сэрдэгдэх үндэслэл бүхий бусад баримт байгаа бол

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонсгосон этгээдийг яллагдагчаар тооцно.

### Төрийн санхүү

Орон нутгийн төсвийн суурь орлого гэж тухайн шатны төсөвт орох татварыг доод хувь хэмжээгээр тооцсон орлого болон татварын бус орлогын нийлбэрийг хэлнэ.

Орон нутгийн суурь зарлага гэж сум, аймаг, нийслэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй холбогдох урсгал болон хөрөнгийн зарлага, нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээ, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг хэлнэ.

Төсвийн тэнцэл гэж тухайн төсвийн жил, улирлын нийт орлого, зарлагын зөрүүг хэлнэ.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж зарцуулах төсөв нь орон нутгийн төсөв байна.

Татварын орлогод орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, хураамж, өмчийн татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, гадаад худалдааны татварын орлого болон бусад татвар орно.

Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, хүү, торгуулийн орлого, түрээсийн орлого, төсөвт газрын өөрийн орлого болон татварын бус бусад орлогоос татварын бус орлого бүрдэнэ.

Төсвийн зарлагыг урсгал зардал, хөрөнгийн зардал, цэвэр зээл гэж ангилна.

Бараа, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс урсгал зардал бүрдэнэ.

### Үнэ

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн

өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглана.

Хэрэглээний сагс нь дундаж зарлагатай өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хэрэглээний үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тооцоход бараа, үйлчилгээний тоо хэмжээ, төрөл, чанар зэргийг тогтмолоор авч үздэг.

Хэрэглээний бараа үйлчилгээний жин гэж өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувийн жин юм.

ХҮИ-ийн тооцоонд Ласпейресийн үнийн индексийн томъёог ашиглаж болно.

$$I_p^L = \frac{\sum_{i=1}^n p_{it} * q_{io}}{\sum_{i=1}^n p_{io} * q_{io}}$$

$I_p^L$  - t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс

t - тайлан үе

o - суурь үе

$p_{it}$  - 'i' барааны тайлант үеийн үнэ,

$p_{io}$  - 'i' барааны суурь үеийн үнэ,

$q_{io}$  - 'i' барааны суурь үеийн худалдан авсан тоо, хэмжээ,

$\sum$  - нийлбэрийн тэмдэг

### Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгжүүдийн

тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар нь ангилахдаа НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд үндэслэсэн үндэсний ангиллыг мөрдөж байна.

### Ерөнхий тэмдэглэл

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв (I, II, III, IV, V, ... гэх мэт)

Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-X зэргээр илэрхийлэв.

II. Дараах тэмдэглэлийг ашиглав:

... мэдээлэл байхгүй

0.0 маш бага тоо

- гүйцэтгэл байхгүй

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

## I. Нийгмийн үзүүлэлт




### I.1 Хүн ам

2019 оны 2-р сарын байдлаар иргэний бүртгэлд шинээр төрсөн 159 хүүхэд, нас барсан 59 хүний бүртгэлийг бүртгэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс шинэ төрсөн хүүхэд 8 буюу 4.7 хувиар буурсан бол, нас баралтын бүртгэл 8 буюу 15.6 хувиар тус өсчээ.

Зураг I.1.2

Бүртгэгдсэн төрөлт, нас баралт



2-р сарын байдлаар 131 хүн шилжин ирж, 103 хүн шилжин явсан нь өмнөх оны мөн үеийнхээс шилжин ирсэн хүн 67 буюу 33 хувиар, шилжин явсан хүн 102 буюу 49 хувиар тус тус буурсан байна.

Зураг I.1.3

Бүртгэгдсэн шилжих хөдөлгөөн



### I.2 Бүртгэлтэй, ажилгүй иргэн

Аймгийн хөдөлмөрийн хэлтэст ажил хайгч иргэн 1641 болсны 759 нь эмэгтэй байна. Ажил хайгч иргэдийн 0.3 магистр, докторын, 16.5 хувийг бакалаврын болон дипломын боловсролтой, 3.4 хувийг тусгай мэргэжлийн дунд, 4.4 хувийг техникийн болон мэргэжлийн, 58.8 хувийг бүрэн дунд боловсролтой, 12.6 хувийг суурь боловсролтой, 2.9 хувийг бага боловсролтой, 1.2 хувийг боловсролгүй иргэд эзэлж байна.

Зураг I.2.1

Ажлын шинэ байранд болон ажилд зуучлагдан орсон иргэд



Аймгийн хэмжээнд ажил хайгч иргэдийн 11.6 хувийг 15-24 насны, 35.6 хувийг 25-34 насны, 25.5 хувийг 35-44 насны, 21.1 хувийг 45-54 насны, 4.8 хувийг 55-59 насны, 1.4 хувийг 60-аас дээш насны хүмүүс эзэлж байна.

Зураг I.2.2

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр



### I.3. Нийгмийн даатгал, халамж Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангийн орлого 2019 оны 2-р сарын байдлаар 1680.4 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 222.8 сая төгрөг буюу 15.3 хувиар өсч, зарлага 6805 сая төг болж өмнөх оны мөн үеэс 1195.2 сая төг буюу 21.3 хувиар өссөн байна.

Тэтгэврийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс 247.8(20.6%) сая төгрөгөөр,

тэтгэмжийн даатгалын сангийн орлого 4.2(3.0%) сая төгрөгөөр, ажилгүйдлын даатгалын сангийн орлого 5.9(17.6%) сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна. Харин үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн орлого 35.1(44.2%) сая төгрөгөөр буурсан байна. Нийгмийн даатгалын сангийн зарлага 2019 оны 2-р сарын байдлаар 6805.0 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн зарлага 10.6(19.4%) сая төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 11.3(20) сая төгрөгөөр буурсан хэдий ч тэтгэврийн даатгалын сангийн зарлага 1189.8(22.4%) сая төгрөгөөр, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 27.3(15.3%) сая төгрөгөөр, өссөн нь голлон нөлөөлөв.

**Нийгмийн халамж**

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 2019 оны 2-р сарын байдлаар 19761 хүн 959.5 сая төгрөгийн тэтгвэр, тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авагчид 206.1 сая.төг буюу 27.4 хувиар өсч, харин нийгмийн халамжийн тэтгэвэрт 1534 хүн хамрагдаж 300.4 сая.төг олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс 29.9 сая.төг буюу 11 хувиар өссөн байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээ, хөнгөлөлтөд 2019 оны 2-р сарын байдлаар 11622 хүн хамрагдсаны 9.5 хувь нь нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламжид хамрагдсан иргэд, 1.7 хувь ахмад настан, 0.7 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 88.1 хувь хүнс тэжээл хөтөлбөр хамрагдсан байна. Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлтөд 245.5 сая.төг олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс 43.6 сая.төг буюу 15.1 хувиар өссөн байна.




**I.4 Эрүүл мэнд**

Аймгийн хэмжээнд 2019 оны 2-р сарын байдлаар 120 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн тоо 124

болж, өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эх 26 буюу 18 хувиар, амьд төрсөн хүүхдийн тоо 24 буюу 16 хувиар тус тус буурсан байна.

**Зураг I.4.1**


Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд,



Нялхасын эндэгдэл 2019 оны 2-р сарын байдлаар 6 гарсан байна

**Зураг I.4.2**

Эндсэн хүүхэд



Халдварт өвчнөөр өвчлөгсөд 2019 оны жилийн 2-р сарын байдлаар 79 болж, өмнөх оны мөн үеийнхээс 19 тохиолдол буюу 32 хувиар өссөн байна. Нийт халдварт өвчнөөр өвчлөгсдийн 31 буюу 39 хувь нь амьсгалын замын халдварт өвчин, 35 буюу 44 хувь нь бэлэгсийн замын халдварт өвчнөөр өвчилсөн байна.

**Зураг I.4.3**

Халдварт өвчнөөр өвчлөгсөд




**I.6 Гэмт хэрэг**

Аймгийн хэмжээнд 2019 оны 2-р байдлаар байдлаар 94 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 42 хэргээр буюу 80.7 хувиар өссөн байна.

**Зураг I.6.1**


Бүртгэгдсэн гэмт хэрэг



- Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 20 бүртгэгдэж 5 хэргээр буюу 33.3 хувиар
- Мал хулгайлах гэмт хэрэг 29 бүртгэгдэж 27 хэргээр буюу 10.1 дахин
- Залилах гэмт хэрэг 8 бүртгэгдэж 6 хэргээр буюу 3 дахин
- Хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 4 бүртгэгдэж 1 хэргээр буюу 33.3 хувиар
- Хүнийг алах гэмт хэрэг 1 бүртгэгдэж 1 хэргээр буюу 100 хувиар өссөн байна.
- Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 4 бүртгэгдэн 4 хэргээр буюу 50 хувиар
- Хулгайлах гэмт хэрэг 11 бүртгэгдэж 1 хэргээр буюу 8.3 хувиар тус тус буурсан байна.

**Зураг I.6.1**

Бүртгэгдсэн гэмт хэрэг



Гэмт хэргийн улмаас нийт иргэд, аж ахуй нэгж байгууллагад 213.1 сая төгрөгний хохирол учирснаас иргэдэд 191.7 сая төгрөгний хохирол учирсан байна. Үүнээс бүртгэлд мөрдөн байцаалтын шатанд 33.7 сая төгрөг буюу 15.8 хувийн хохирлыг нөхөн төлүүлж ажилласан байна. Гэмт хэргийн улмаас 7 хүн нас барсан ба өнгөрсөн оны мөн үеийнхээс 12.5 хувиар буурсан байна. Бусдыг амиа хорлоход хүргэсэн гэмт хэргийн улмаас 3 хүн, бусад хэргийн улмаас 1 хүн амь насаа

алдсан байна.

Хэргийн өнгөөр нь авч үзвэл: Гэмт хэргийн улмаас 21 хүн гэмтсэн нь ХЭМХБЭГХ-ийн улмаас 20 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 23.5 хувиар өссөн байна.

**Зураг I.6.3**

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан, жил бүрийн 2-р сарын байдлаар



2019 оны 2-р сарын байдлаар 6333 зөрчилд 176.7 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна. Гудамж талбайд хэвийн бус явж орон гэртээ агсан согтуу тавьсны улмаас 144 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеийхээс 68 хүнээр буюу 89.4 хувиар өссөн байна. Захиргааны журмаар 24 хүнийг баривчилж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож эрхээ хасуулж, торгуулсан 35 иргэн байна.



**II.Эдийн засгийн үзүүлэлт**


**II.1 Аймгийн төсөв**

Аймгийн төсвийн нийт орлого 2019 оны 2-р сарын байдлаар 9264.1 сая төгрөг, зарлага 7875.9 сая төгрөг болж, аймгийн төсвийн нийт тэнцэл 1388.2 сая төгрөгний эерэг гарлаа.

**Зураг II.1.1**

Аймгийн төсвийн орлого, зарлага


сая төг



Орон нутгийн төсвийн орлогын 40.7 хувийг татварын орлого, 6 хувийг татварын бус орлого, 59.3 хувийг улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг эзэлж байна. Төсвийн зарлага 2019 оны 1-р сарын байдлаар 7875.9 сая.төг болоход 91 хувийг бараа ажил үйлчилгээний зардал, 8 хувийг урсгал шилжүүлгийн зардал эзэлж байна.

**Зураг II.1.2**

Аймгийн төсвийн өр, авлага сараар



Нийт өр 67.6 сая төгрөг байна. Өр өмнөх оны мөн үетэй харьцуулбал 20.0 сая төгрөгөөр бага дүнтэй байна.




**II.3 Үнэ**

**Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ**

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс аймгийн хэмжээнд 2019 оны 2-р сарын байдлаар өмнөх оны мөн үеийнхээс 4.9 хувиар, өмнөх сарынхаас 0.4 хувиар өссөн байна.

**Зураг II.3.1**

Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн индекс, хувь, 2019 I-XII сар, (өмнөх сар=100%)



**Хүснэгт II.3.1**

Хэрэглээний үнийн аймгийн индекс (суурь үе буюу 2019-1=100хувь)

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2019 II 2018 II	2019 II 2018 XII	2019 II 2019 I
Ерөнхий индекс	100.0	104.9	101.3	100.4
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	103.7	104.9	100.4
Согтууруулах ундаа, тамхи	3.2	101.0	101.3	100.0
Хувцас, бас, бараа, гутал	16.1	103.4	101.0	100.6
Орон сууц, ус, цахилгаан, түүш	12.3	100.5	100.0	100.0
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	103.8	100.1	99.9
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	122.5	100.5	100.3
Тээвэр	12.2	107.4	98.6	101.2
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	102.3	100.0	100.0
Амралт, чөлөөлт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	125.1	100.8	100.3
Боловсролын үйлчилгээ	4.7	100.0	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	107.3	107.2	107.2
Бусад бараа, үйлчилгээ	4.1	99.4	99.9	99.6

**II.4 Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ**

Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн судалгаагаар 2019 оны 2 сарын байдлаар үхрийн 1.8-2.3 м урттай шир 3.4 мян.төгрөг, 2.3 м-с дээш урттай шир 3.4 мян. төгрөг, адууны шир 5.0 мян.төгрөг, ямааны арьс 30.0 мян.төгрөг, хонины нэхий өлөнгүй бол зах зээлд нийлүүлэлт байхгүй болсон байна. Өмнөх онтой харьцуулвал ямааны ноолууртай арьс 27.6 хувиар өссөн бол үхрийн 1.8-2.3 метрийн урттай шир 85.5 хувиар, 2.3 метрийн урттай шир 89.5 хувиар, адууны шир 66.6 хувиар тус тус буурсан байна.

**II.5 Малын дундаж үнэ**

Малын дундаж үнэ: 2019 оны 2 сарын байдлаар тэмээ 888.0 мян.төг, адуу 754.0 мян.төг, үхэр 864.0 мян.төг, хонь 129.0 мян. төг, ямаа 99.0 мян.төг болж буюу өмнөх онтой харьцуулвал тэмээ 6.5 хувиар буурсан бол адуу 29.2 хувиар, үхэр 22.5 хувиар, хонь 28.7 хувиар, ямаа 32.4 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.




**II.6 Аж үйлдвэр**


Аймгийн аж үйлдвэрийн газрууд 2019 оны 2-р сарын байдлаар 1171.8 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 1915.0 сая төгрөгийн бүтээгдэхүүний борлуулалт нийсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлт 18.9 хувиар, борлуулалт 16.4 хувиар тус тус өссөн байна.

Зураг II.6.1

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлт, борлуулалт



Зүй бусаар хорогдсон том мал, сумаар, 2 сарын байдлаар, толгой




**II.14 Хөдөө аж ахуй  
Зүй бусын хорогдол**

Том малын зүй бусын хорогдол 2019 оны 2 сарын байдлаар 2.7 мян.толгой болж, өмнөх оны мөн үеийнхээс 18.8 мян.толгой мал буюу 12.7 хувиар өссөн байна. Нийт хорогдлыг малын төрлөөр авч үзвэл адуу 237 толгой буюу 0.09 хувь, үхэр 371 толгой буюу 0.13 хувь, хонь 1003 толгой буюу 0.06 хувь, ямаа 1122 толгой буюу 0.11 хувь нь оны эхний малаас тус тус хорогдоод байна. Нийт хорогдлын адуу 8.7 хувь, үхэр 13.6 хувь, ямаа 41.1 хувь, хонь 36.7 хувийг тус тус эзэлж байна. Хорогдлыг сумаар авч үзвэл Хутаг-Өндөр сум 23.3 хувийг, Тэшиг сум 15 хувь, Баян-агт сум 14.2 хувийг тус тус эзэлж байгаа нь дийлэнх болж байна.

Зураг II.14.1

Том малын зүй бусын хорогдол




## I.I ХҮН АМ

## Хүснэгт I.I.1 Хүн ам, өрх

Сум	Хүн ам				2018 2017	Эрэгтэй				2018 2017	Эмэгтэй				2018 2017
	2015	2016	2017	2018		2015	2016	2017	2018*		2015	2016	2017	2018	
Баян-Агт	3052	3119	3218	3251	101.0	1550	1583	1632	1645	100.8	1502	1536	1632	1604	100.9
Баяннуур	1868	1818	1861	1827	98.2	983	969	998	976	97.8	885	849	998	850	97.9
Бугат	2182	2241	2277	2198	96.5	1132	1187	1208	1157	95.8	1050	1054	1208	1041	95.8
Булган	12234	12512	12616	12582	99.7	6014	6104	6125	6150	100.4	6220	6408	6125	6422	100.6
Бүрэгхангай	2726	2832	2888	2872	99.4	1388	1459	1482	1469	99.1	1338	1373	1482	1399	99.4
Гурванбулаг	3133	3176	3219	3289	102.2	1617	1644	1660	1686	101.6	1516	1532	1660	1601	101.7
Дашинчилэн	2803	2941	3037	3008	99.0	1431	1492	1540	1523	98.9	1372	1449	1540	1482	99.1
Могод	2685	2701	2729	2711	99.3	1375	1383	1394	1392	99.9	1310	1318	1394	1318	99.9
Орхон	3482	3584	3595	3477	96.7	1865	1911	1913	1856	97.0	1617	1673	1913	1615	97.3
Рашаант	3141	3165	3215	3253	101.2	1583	1602	1618	1641	101.4	1558	1563	1618	1607	101.7
Сайхан	3575	3648	3662	3561	97.2	1816	1854	1871	1799	96.2	1759	1794	1871	1757	96.4
Сэлэнгэ	3207	3306	3332	3343	100.3	1666	1723	1733	1743	100.6	1541	1583	1733	1598	100.7
Тэшиг	3495	3504	3563	3560	99.9	1786	1782	1820	1809	99.4	1709	1722	1820	1751	99.4
Хангал	4548	4611	4705	4660	99.0	2282	2302	2343	2331	99.5	2266	2309	2343	2327	99.6
Хишиг-Өндөр	3154	3156	3158	3152	99.8	1592	1595	1592	1578	99.1	1562	1561	1592	1570	99.4
Хутаг-өндөр	4729	4835	4952	5050	102.0	2432	2487	2546	2573	101.1	2297	2348	2546	2467	101.5
Нийт хүн ам	60014	61149	62027	61794	99.6	30512	31077	31475	31328	99.5	29502	30072	31475	30409	99.7

## Зураг I.I.1 Хүн амын нас хүйсийн суварга 2018 он



## I.4 ЭРҮҮЛ МЭНД

**Хүснэгт I.4.1** Аймгийн хэмжээнд гарсан халдварт өвчин, өвчний төрлөөр оноор

Үзүүлэлт	2015 II	2016 II	2017 II	2018 II	2019 II	2018/2017
Амаржсан эхийн тоо	184	144	135	146	120	82%
Амьд төрсөн хүүхэд	183	145	137	148	124	84%
Эхийн эндэгдэл	-	-	-	-	-	-
Амьгүй төрөлт	3	1	3	-	-	-
Гэрийн төрөлт	-	1	1	1	-	-
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	3	1	2	4	6	150%
Перинаталь эндэгдэл	5	2	2	4	5	125%
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насанд эндсэн хүүхэд	16.4	6.9	14.6	27	48.4	179%

**Хүснэгт I.4.2** Аймгийн хэмжээнд гарсан халдварт өвчин, өвчний төрлөөр, оноор

Үзүүлэлт	2015 II	2016 II	2017 II	2018 II	2019 II	2018/2017
Нийт гарсан халдварт өвчин	54	76	113	60	79	132%
Гэдэсний халдварт өвчин	3	0	3	2	5	250%
Амьсгалын замын халдварт өвчин	21	34	65	25	31	124%
Байгалын голомтот халдварт өвчин	0	0	0	1	1	100%
Бэлэгсийн замаар дамжих халдварт өвчин	24	34	39	25	35	140%
Арьсны халдварт өвчин	6	8	6	7	7	100%

## I.5 ГЭМТ ХЭРЭГ

**Хүснэгт I.4.1** Бүртгээгдсэн гэмт хэрэг, оноор, 2-р сарын байдлаар

Сум	2015 I-II	2016 I-II	2017 I-II	2018 I-II	2019 I-II	2019 I-II % 2018 I-II
Булган	22	21	17	16	21	131.3
Баян-Агт	1	1	1	2	6	300.0
Баяннуур	2	1	2	2	7	350.0
Бугат	5	3	4	6	3	50.0
Бүрэгхангай	7	5	3	1	5	500.0
Гурванбулаг	4	3	4	3	1	33.3
Дашинчилэн	4	3	1			0.0
Могод	2	6	1	2		0.0
Орхон	5	7	4	6	24	400.0
Рашаант	1	2	2	1	8	800.0
Сайхан	1	1	2	2	1	50.0
Сэлэнгэ	2	1	5	3	3	100.0
Тэшиг		1	1	2	1	50.0
Хангал		1	2	2		0.0
Хишиг-Өндөр	2	2	6		8	0.0
Хутаг-Өндөр	1	2	2	2	5	250.0
Хялганат	1	1	2	1	1	100.0
Бүгд	60	61	59	51	94	184.3

**Хүснэгт 1.4.2 Хулгайн гэмт хэрэг, сумаар, оноор, 2-р сарын байдлаар**

Сум	2015 I-II	2016 I-II	2017 I-II	2018 I-II	2018 I-II
Булган	4	6	6	8	3
Баян-Агт				1	4
Баяннуур	2		2		3
Бугат	2	2	2		1
Бүрэгхангай	5	1	1		
Гурванбулаг	1		2		3
Дашинчилэн	4	2			
Могод		2	1	1	
Орхон	4	3	2	2	22
Рашаант	1	1	1		2
Сайхан		1	2	1	1
Сэлэнгэ			1		
Тэшиг				1	
Хангал					
Хишиг-Өндөр		1	2		2
Хутаг-Өндөр			1		2
Хялганат					
Бүгд	23	19	23	14	43

**Хүснэгт 1.4.3 Сумдын хэргийн илрүүлэлт 2019 оны 2-р сарын байдлаар**

Сум	Бүртгэгдэх үедээ сэжигтэн этгээд нь тогтоогдоогүй хэрэг		Яллагдагчаар татаж ял сонгосон хэрэг	
	2018	2019	2018	2019
Булган	11	16	3	4
Баян-Агт	2	5	1	
Баяннуур	1	4	1	1
Бугат	5	2	1	
Бүрэгхангай	1	4		
Гурванбулаг	3	1	1	1
Дашинчилэн				
Могод	1		1	
Орхон	6	25		
Рашаант		6		1
Сайхан	2	1		
Сэлэнгэ	5	3	1	
Тэшиг	2		1	
Хангал	2			
Хишиг-Өндөр		6		1
Хутаг-Өндөр	2	4		
Хялганат	1			
Бүгд	44	77	10	8

**Хүснэгт I.4.4 Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, оноор, 2-р сарын байдлаар**

Үзүүлэлт	2015 I-II	2016 I-II	2017 I-II	2018 I-II	2019 I-II	2018 II% 2017 II
	сая төгрөг					
Учирсан хохирол- Бүгд	132.6	145.0	144.8	128.4	200.3	156.0
Үүнээс						
Нөхөн төлүүлсэн	89.4	74.3	84.6	76.7	20.7	27.0
Нөхөн төлүүлэлтийн хувь	67.4	51.2	58.4	59.7	10.3	17.3

## II.3 ҮНЭ

**Хүснэгт II.3.1 Хэрэглээний үнийн ерөнхий индекс, барааны бүлгээр**

Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	Жин	2019 II 2018 II	2019 II 2018 XII	2019 II 2019 I
Ерөнхий индекс	100.0	104.9	101.3	100.4
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	103.7	104.9	100.4
Согтууруулах ундаа, тамхи	3.2	101.0	101.3	100.0
Хувцас, бөс бараа гутал	16.1	103.4	101.0	100.6
Орон сууц, ус цахилгаан, түлш	12.3	100.5	100.0	100.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	4.7	103.8	100.1	99.9
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	122.5	100.5	100.3
Тээвэр	12.2	107.4	98.6	101.2
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	102.3	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	125.1	100.8	100.3
Боловсролын үйлчилгээ	4.7	100.0	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	2.6	107.3	107.2	107.2
Бусад бараа, үйлчилгээ	4.1	99.4	99.9	99.6

**Хүснэгт II.3.2 Хүнсний гол нэр төрлийн барааны 7 хоногийн ажиглалт 2019 оны 2-р сарын сүүлийн 7 хоног, 2018 оны 2-р сарын сүүлийн 7 хоногтой харьцуулсан**

Барааны нэр төрөл		2018 II/28	2019 II/27	2018 II/28 2019 II/27
"Алтан тариа" дээд, савласан	гурил	1500	1600	106.7
гурил	I зэрэг, задгай	1300	1300	100.0
Орон нутгийн	"Хангай" 1-р	1100	1100	100.0
гурил	гурил"			
	"Орхон мандал"	2500	2500	100.0
	1-р гурил			
Талх "Ундрах" аймгийн үйлвэр		2000	2000	100.0
Цагаан будаа		2000	2000	100.0
Элсэн чихэр		2700	3000	111.1
Сүү	Задгай	4300	4300	100.0
	"Цэвэр сүү"	7000	8500	121.4

Ургамлын тос, "Кларина"		5000	7000	140.0
Мах	Үхрийн	6000	6000	100.0
	Хонины	3500	6000	171.4
	Адууны	1000	1000	100.0
	Ямааны	1500	1300	86.7
Ногоо	Төмс /монгол/	1500	1300	86.7
	Лууван /монгол/	1500	1500	100.0
	Байцаа /монгол/	2500	2000	80.0
	Манжин /монгол/	1500	1500	100
	Сонгино /монгол/	500	300	60.0
	Сонгино /хятад/	1500	1500	100
	Сармис	500	400	80.0



### Хүснэгт II.3.3 Хүнсний гол нэр төрлийн барааны ажиглалт, оноор, 2-р сарын байдлаар

Барааны нэр төрөл		Хэмжих нэгж	2015	2016	2017	2018	2019	2019 II 2018 II
"Алтан тариа"	I зэрэг	кг	1400	1283	1333	1333	1325	99.4
гурил /задгай/	II зэрэг	кг	900	1000	1000	1100	1000	90.9
Будаа	Цагаан	кг	2400	2466	2517	2467	2467	100.0
	Шар	кг	1900	1900	1900	1900	3375	177.6
Элсэн чихэр		кг	1700	1666	2466	2217	1867	84.2
Хонины мах	ястай	кг	5500	4000	5000	5000	7000	140.0
	цул	кг	5500	4000	5000	5000	7000	140.0
Үхрийн мах	ястай	кг	7000	5500	5500	7500	8500	113.3
	цул	кг	7000	5500	6000	7500	9000	120.0
Адууны мах		кг	5500	4000	4000	6000	6500	108.3
Ямааны мах		кг	4500	3500	3500	4000	6000	150.0
Сүү	задгай	л	2000	2000	2000	2000	2000	100.0
	"Цэвэр сүү"	л	2750	2633	2633	2683	2760	102.9
Байцаа	монгол	кг	1000	1000	800	1500	1267	84.5
Лууван	монгол	кг	1000	1800	800	1500	1200	80.0
Манжин	монгол	кг	1500	2000	800	1500	1500	100.0
Төмс	монгол	кг	1200	1000	700	1000	1000	100.0
Сонгино	хятад	кг	1500	1500	1500	1375	2000	145.5
Сармис, булцуу		кг	300	350	500	400	300	75.0
Ургамлын тос		л	3600	3566	3866	3667	3900	106.4
Өндөг		ш	350	300	350	333	367	110.2
Талх "Ундрах" орон нутгийн		ш	900	1066	1100	1067	1100	103.1

**Хүснэгт II.3.4 Нэг литр шатахууны үнэ, 2019 оны 1-р сарын байдлаар**

ШТС	АИ 95	АИ 92	АИ 80	Дезил түлш	Газ
Шунхлай	0	1745	1675	2275	0
Тэс	0	1740	1710	2290	0
Магнай трейд	2300	1750	1670	2300	0
Петровис	0	0	0	0	1350
Гиг газ	0	0	0	0	1250


**Зураг II.3.1 Нэг кг хүнсний ногооны дундаж үнэ, 2019 оны 2-р сарын байдлаар**



**Нэг кг хонины махны үнэ, төгрөг**



**Нэг кг үхрийн махны үнэ, төгрөг**



**Хүснэгт II.3.5 Малын гаралтай бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ, 2018, 2019 оны 2-р сарын байдлаар, төгрөгөөр**

№	Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	2018-II	2019-II
1	Цагаан ноолуур	кг	47500	88000
2	Бор ноолуур	кг	47500	88000
3	Адууны шир	ш	15000	5000
4	Адууны дэл	ш	5000	4800
5	Адууны сүүл	ш	6000	7600
6	Үхрийн шир 1.8-2.3 метрийн хэмжээтэй шир	ш	23500	3400
7	Үхрийн шир 2.3 метрээс дээш хэмжээтэй шир	ш	32500	3400
8	Хонины ноостой нэхий	ш	3000	-
9	Ямааны ноолууртай арьс	ш	23500	30000

**Хүснэгт II.3.10 Малын зах зээлийн дундаж үнэ, мян.төгрөг, 2-р сарын байдлаар**

Нэр	2018-II	2019-II	2019 II/ 2018 II	Нэр	2018-II	2019-II	2019 II/ 2018 II
<b>Буур</b>	900	913	101.4	<b>Шүдлэн гунж</b>	394	520	132.0
Нас гүйцсэн ат	950	888	93.5	Эр тугал	151	215	142.4
Нас гүйцсэн ингэ	867	750	86.5	Эм тугал	147	209	142.2
Эр шилбэ	517	450	87.0	<b>Хуц</b>	140	130	92.9
Эм шилбэ	517	450	87.0	Эр хонь	100	129	129.0
Эр ботго	233	233	100.0	Эм хонь	75	94	125.3
Эм ботго	233	233	100.0	Эр төлөг	51	68	133.3
<b>Азарга</b>	852	914	107.3	Эм төлөг	48	66	137.5
Соёолон үрээ	597	754	126.3	Эр хурга	25	40	160.0
Соёолон гүү	553	679	122.8	Эм хурга	25	40	160.0
Шүдлэн үрээ	377	479	127.1	<b>Ухна</b>	109	105	96.3
Шүдлэн байдас	377	471	124.9	Эр ямаа	75	99	132.0
Эр унага	150	203	135.3	Эм ямаа	54	77	142.6
Эм унага	152	203	133.6	Эр борлон	36	56	155.6
<b>Бух</b>	808	1015	125.6	Эм борлон	35	45	128.6
Хязаалан шар	705	864	122.6	Эр ишиг	20	27	135.0
Хязаалан дөнж	623	768	123.3	Эм ишиг	20	27	135.0
Шүдлэн эр үхэр	414	547	132.1				

**II.6 АЖ ҮЙЛДВЭР****Хүснэгт II.6.1 Аж үйлдвэрийн салбарын борлуулалт, жил бүрийн 2-р сарын байдлаар**

Салбараар	Нийт бүтээгдэхүүн (оны үнээр, мян.төг)		
	2018 I-II	2019 I-II	2019 I-II % 2018 I-II
Нийт дүн			
<b>Уул уурхай, олборлох аж үйлдвэр</b>	<b>284460.5</b>	<b>0</b>	<b>0.0</b>
Нүүрс олборлолт	284460.5	0	0.0
<b>Боловсруулах аж үйлдвэр</b>	<b>432192.6</b>	<b>971616</b>	<b>224.8</b>
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	419817.6	956592	227.9
Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	204359.6	512580	250.8
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	16127	0	0.0
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл	45827.5	246802	538.5
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	153503.5	197210	128.5
Нэхмэлийн үйлдвэрлэл	5475	12304	224.7
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	6900	2520	36.5
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	0	200	0.0
<b>Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэл</b>	<b>928261.5</b>	<b>943454.6</b>	<b>101.6</b>

**Хүснэгт II.6.2 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, салбараар, 1-р сарын байдлаар**

Бүтээгдэхүүний нэрс	Хэмжих нэгж	Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт					
		Биет хэмжээ			Үнийн дүн / мян.төг/		
		2017 II	2018 II	2018 II % 2017 II	2017 II	2018 II	2018 II % 2017 II
А	Б	1	2		3	4	
Чулуун нүүрс	мян.тн	6.9	0	0.0	284460.5	0	0.0
Бог будаа	тн	0.39	0.78	200.0	3120	6240	200.0
Дулааны эрчим хүч	мян.Гкал	3	6.5	216.7	232633.3	202999.9	87.3
Үхрийн мах	тн	13.915	25.2	181.1	108909	434000	398.5
Хонины мах	тн	9	0	0.0	35200	0	0.0
Ямааны мах	тн	3	0	0.0	10500	0	0.0
Адууны мах	тн	1	0	0.0	3800	0	0.0
Дайвар бүтээгдэхүүн	тн	0.134	8.57	6395.5	898.9	47400	5273.1
<b>Хиамны зүйл</b>	тн	1.66	0.46	27.7	7867	3280	41.7
Утсан, чанасан болон бусад боловсруулалт хийсэн ма	тн	0.65	0	0.0	7753	0	0.0
Бүх төрлийн ногооны консерв	тн	0	2.4	0.0	0	10800	0.0
Дүфү	тн	1.8	0	0.0	5400	0	0.0
Жимсний чанамал	тн	0.05	0.275	550.0	800	1375	171.9
Айраг	мян.л	3.6	0	0.0	14762	0	0.0
Гурил Дээд	тн	0	50.84	0.0	0	53786.3	0.0
Гурил I зэрэг	тн	85.2	153.9	180.6	72441.3	123211	170.1
Гурил II зэрэг	тн	1.2	3.25	270.8	735	2190	298.0
Арвайн гурил	тн	7.855	12.055	153.5	7644.2	12545	164.1
Багсармал болон бусад малын тэжээл	тн	0	12.7	0.0	0	3829	0.0
Хивэг	тн	2.3	103.54	4501.7	931.6	43701	4691.0
Нарийн боов	тн	26	23.02	88.5	41500	56740	136.7
Бялуу	тн	0.161	2.122	1318.0	2303	34800	1511.1
Хэвийн боов	тн	11	9.1	82.7	57600	48400	84.0
Талх	тн	10	5.43	54.3	8520	7190	84.4
Эмчилгээний цай	кг	180	342	190.0	4500	8550	190.0
Бусад цай	кг	38	34.2	90.0	1700	1520	89.4
Банш, бууз, хуушуур	тн	0.33	0	0.0	1413.6	0	0.0
Энержи дринк	мян.л	0.12	0.176	146.7	1375	1475	107.3
Ноосон хүрэм	ш	5	0	0.0	500	0	0.0
Ноосон плате, банзал	ш	3	0	0.0	135	0	0.0
Ноосон майк, путболька	ш	0	120	0.0	0	2400	0.0
Ноосон цамц	ш	10	75	750.0	350	2550	728.6
Ноолууран алчуур, нөмрөг	ш	10	0	0.0	250	0	0.0
Ажлын хувцас	ш	16	25	156.3	1085	2500	230.4
Монгол дээл,тэрлэг	ш	45	22	48.9	6000	1240	20.7
Өвлийн малгай	ш	15	20	133.3	225	280	124.4
Үртсэн шахмал түлш	тн	0	1	0.0	0	200	0.0
Түгээсэн цэвэр ус	мян.м3	3.1	8.6	277.4	48992.5	48111.5	98.2
Сувагжуулалт	мян.м3	1.1	6.2	563.6	10046	10239.7	101.9
Ноолууран хүрэм	ш	2	0	0.0	520	0	0.0
Ноолууран алчуур, нөмрөг	ш	10	0	0.0	250	0	0.0

## II.14 МАЛ АЖ АХУЙ

**Хүснэгт II.14.1 Малын тоо 2018 он**

Сумын нэр	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Булган	62283	0	5842	6723	29350	20368
Баянагт	304136	33	19670	20722	160651	103060
Баяннуур	109054	300	6157	8088	55786	38723
Бугат	109859	0	10196	15688	50674	33301
Бүрэгхангай	274808	129	17593	18095	150483	88508
Гурванбулаг	277930	170	15630	9038	156977	96115
Дашинчилэн	220804	161	12452	11786	125095	71310
Могод	292921	52	22772	13626	188789	67682
Орхон	308370	69	27223	24475	149593	107010
Рашаант	182772	352	11277	7872	100705	62566
Сайхан	348051	76	37342	17306	216508	76819
Сэлэнгэ	95929	0	9114	20576	40093	26146
Тэшиг	89566	0	8513	21795	33431	25827
Хангал	91311	2	6945	17914	35333	31117
Хишиг-Өндөр	214408	0	14195	8732	121944	69537
Хутаг-Өндөр	323293	31	19115	32828	162812	108507
Бүгд	3305495	1375	244036	255264	1778224	1026596

**Хүснэгт II.14.8 Зүй бусаар хорогдсон том мал, төрлөөр, оноор**

Малын төрөл	Хорогдсон том мал, толгой			Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь		
	2017 I-II	2018 I-II	2019 I-II	2017 I-II	2018 I-II	2019 I-II
Бүгд	6423	21545	2733	0.2	0.6	0.08
Адуу	720	2836	237	0.3	1.0	0.09
Үхэр	691	5546	371	0.3	1.9	0.13
Тэмээ	0	0	0	0.0	0.0	0.00
Хонь	2624	6321	1003	0.1	0.3	0.06
Ямаа	2388	6842	1122	0.2	0.6	0.11

**Хүснэгт II.14.9 Хорогдсон том мал, төрлөөр, сумаар, 2019 оны 2-р сарын байдлаар**

Сум	Хорогдсон том мал						Оны эхний малд эзлэх хувь					
	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Булган	5	0	0	0	3	2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Баян-Агт	387	31	49	0	162	145	0.1	0.2	0.2	0.0	0.1	0.1
Баяннуур	27	2	3	0	9	13	0.02	0.03	0.04	0.00	0.02	0.03
Бугат	87	27	8	0	30	22	0.08	0.26	0.05	0.00	0.06	0.07
Бүрэгхангай	102	12	15	0	36	39	0.04	0.07	0.08	0.00	0.02	0.04
Гурван булаг	21	1	1	0	9	10	0.01	0.01	0.01	0.00	0.01	0.01
Дашинчилэн	319	43	45	0	115	116	0.14	0.35	0.38	0.00	0.09	0.16
Могод	19	1	1	0	9	8	0.01	0.00	0.01	0.00	0.00	0.01
Орхон	379	28	22	0	157	172	0.12	0.10	0.09	0.00	0.10	0.16
Рашаант	0	0	0	0	0	0	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Сайхан	291	31	30	0	170	60	0.08	0.08	0.17	0.00	0.08	0.08
Сэлэнгэ	23	1	5	0	9	8	0.02	0.01	0.02	0.00	0.02	0.03
Тэшиг	410	40	98	0	124	148	0.46	0.47	0.45	0.00	0.37	0.57
Хангал	8	2	6	0	0	0	0.01	0.03	0.03	0.00	0.00	0.00
Хишиг-өндөр	18	0	0	0	10	8	0.01	0.00	0.00	0.00	0.01	0.01
Хутаг-Өндөр	637	18	88	0	160	371	0.20	0.09	0.27	0.00	0.10	0.34
Бүгд	2733	237	371	0	1003	1122	0.08	0.09	0.13	0.00	0.06	0.11

**Хүснэгт II.14.9 Өвчнөөр хорогдсон том мал, сумаар, 2019 оны 2-р сарын байдлаар**

Сум	Хорогдсон том мал						Оны эхний малд эзлэх хувь					
	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Булган	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Баян-Агт	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Баяннуур	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бугат	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бүрэгхангай	2	0	1	0	0	1	1.96	0	6.67	0	0	2.56
Гурван булаг	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Дашинчилэн	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Могод	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Орхон	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Рашаант	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Сайхан	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Сэлэнгэ	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Тэшиг	11	1	1	0	7	2	2.68	2.5	1.02	0	5.65	1.35
Хангал	4	0	4	0	0	0	50	0	66.67	0	0	0
Хишиг-өндөр	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хутаг-Өндөр	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бүгд	17	1	6	0	7	3	0.6	0.4	1.6	0.0	0.7	0.3

**Хүснэгт II.14.10 Хорогдсон хээлтээгч, сумаар, 2019 оны 2-р сарын байдлаар**

Сум	Хорогдсон том мал						Оны эхний малд эзлэх хувь					
	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Булган	5	0	0	0	3	2	100	0	0	0	100	100
Баян-Агт	25	0	2	0	15	8	7	0	4	0	9	6
Баяннуур	7	0	0	0	3	4	25.9	0	0	0	33.3	30.8
Бугат	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бүрэгхангай	5	0	0	0	2	3	4.9	0	0	0	5.6	7.7
Гурван булаг	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Дашинчилэн	2	0	0	0	2	0	1	0	0	0	2	0
Могод	18	0	1	0	9	8	95	0	100	0	100	100
Орхон	137	6	8	0	43	80	36.1	21	36.4	0.0	27.4	46.5
Рашаант	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Сайхан	97	8	13	0	49	27	33	26	43	0	29	45
Сэлэнгэ	23	1	5	0	9	8	100	100	100	0	100	100
Тэшиг	53	10	11	0	19	13	12.9	25.0	11.2	0	15.3	8.8
Хангал	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хишиг-өндөр	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хутаг-Өндөр	54	2	9	0	25	18	8.5	11	10.2	0	16	5
40674	426	27	49	0	179	171	15.6	11.4	13.2	0	17.8	15.2

## Статистикийн мэдээллийг хэрхэн авах вэ?

**[www.1212.mn](http://www.1212.mn)** Статистикийн мэдээллийн нэгдсэн сан  
**[bulgan.nso.mn](http://bulgan.nso.mn)** Хэлтсийн вэб сайт



Ухаалаг гар утас, таблет ашиглан статистикийн мэдээлэл авах ezStat аппликейшн



Статистикийн хэвлэл бүтээгдэхүүнийг унших Монстат аппликейшн



[www.nso.mn](http://www.nso.mn) сайтад бүртгүүлснээр цахим шуудангаар тогтмол авч болно.



[www.facebook.com/pages/Статистик-Мэдээлэл](http://www.facebook.com/pages/Статистик-Мэдээлэл)  
[www.facebook.com/pages/Булган-аймгийн-засаг-даргын-дэргэдэх-статистикийн-хэлтэс](http://www.facebook.com/pages/Булган-аймгийн-засаг-даргын-дэргэдэх-статистикийн-хэлтэс)



[www.twitter.com/statistic\\_mn](http://www.twitter.com/statistic_mn)



**1900-1212**  
1 минут = 200 төгрөг

**70342766**









СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН  
**WWW.1212.MN**

Хаяг:	Address
Монгол улс, Булган аймаг, Булган сум,	Statistics office, №105, 106
Засаг даргын тамгын газар, 105, 106 тоот	Governors office Bulgan sum,
Статистикийн хэлтэс	Bulgan aimag, Mongolia
Утас:	Phone:
70342766	70342766
И-мэйл:	E-mail:
bulgan@nso.mn	bulgan@nso.mn
вэб:	Web:
www.bulgan.nso.mn	www.bulgan.nso.mn